



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/21


Мандалговь

**Шинэ төрлийн коронавирусын халдварын
Үед ажиллах хүүхэд хамгааллын мэргэжлийн
ангийн төлөвлөгөө батлах тухай**

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.9.3 дахь заалтууд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/29 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ төрлийн коронавирусын халдварын үед ажиллах хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бэлэн байдлын төлөвлөгөөг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 1 157 262 (Нэг сая нэг зуун тавин долоон мянга хоёр зуун жаран хоёр) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн ахлагч (Б.Цэцэг), гишүүдэд үүрэг болгосугай.
4. Төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

481190051